# “НАКО ТҮЛШ” ХК



# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА НЬ МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ӨГСӨН МАТЕРИАЛЫН ХУУЛБАР БӨГӨӨД ТАНИЛЦУУЛГАД ОРСОН МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВИЙГ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ХҮЛЭЭНЭ.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ" БОЛОН МОНГОЛ УЛСЫН "САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО"-НЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

"ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХААР ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА".


**Андеррайтер:**

**Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн**

**"БиДиСЕК" Хувьцаат Компани**

**Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө Оруулалтын Зөвлөх**

**www.bdsec.mn**

**Хаяг:УБ, СБД 8 хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 байр**

**Утас: 323411, 313108**

**Факс: 321763, 323411**

**И-мэйл: info@bdsec.mn www.bdsec.mn**

# Агуулга


1. Нэмэлт хувьцааны товч танилцуулга 4
2. Үнэт цаас гаргагчийн танилцуулга 5
3. Төслийн тухай 7
   - 3.1 Төслийн хэрэгжилт, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 8
   - 3.2 Нэмэлт санхүүжилт, нэмж гаргаж буй хувьцаа 10
   - 3.3 Төслийн эдийн засгийн тооцоолол 15
4. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувьцааны арилжаа 16
5. Эрсдэл 19
6. Хувьцаа хэрхэн худалдан авах 22
7. Андеррайтерын танилцуулга 23
8. Санхүүгийн тайлан /сүүлийн 3 жилээр/ 24
9. Андеррайтерын дүгнэлт 47

## НАКО ТҮЛШ ХК-ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаасны нэр: | “НАКО ТҮЛШ” ХК-ийн хувьцаа |
| Үнэт цаасны төрөл: | Энгийн хувьцаа |
| Үнэт цаасны хэлбэр: | Биет бус |
| Үнэт цаас гаргагчийн хаяг: | Дархан-Уул 15-р баг үйлдвэрийн район |
| Нэрлэсэн үнэ: | 100 төгрөг |
| Нийт гаргасан хувьцааны ширхэг: | 11 000 000 |
| Нэмэлт санхүүжилтын дүн: | 370,000,109 |
| Нэмж гаргаж буй хувьцааны ширхэг: | 1 615 721 |
| Нэмж гаргаж буй хувьцааны үнэ: | 229 төгрөг |
| Зээлийн гэрээний дагуу хувьцаанд хөрвөх тоо ширхэг: | 435,526 |
| Нийтэд санал болгох хувьцааны тоо: | 1,180,195 |
| Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны чиглэл: | Коксын үйлдвэрлэл |
| Үнэт цаасны зарцуулалт: | Үйлдвэрийн угсралтын ажлыг дуусган ашиглалтанд оруулах, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхэд зарцуулана. |
| Андеррайтер: | Хөрөнгө оруулалтын зөвлөх, Андеррайтер, Брокер, Дилерийн “БиДиСЕК” Хувьцаат компани |
| Андеррайтерын хаяг: | Empire Building 27/1 байр, Залуучуудын өргөн чөлөө,8-р хороо, Сүхбаатар дүүрэг Улаанбаатар хот |
| Утас: | 976-11-323411, |
| Факс: | 976-11-313108, 976-11-321763 |
| Вэб сайт: | www.bdsec.mn |
| И- мэйл: | info@bdsec.mn |

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## Компанийн танилцуулга

“Нако түлш” компани нь Монгол улсад анхны хагас коксын үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулах зорилгоор 2007 онд байгуулагдсан. Хагас коксын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл нь анх 2007 оноос хэрэгжиж эхэлсэн ба төсөлд шаардлагатай 900 сая төгрөгийн санхүүжилтийг firm commitment хэлбэрээр татан төвлөрүүлж 2008 оны 7 сард 11 сая ширхэг хувьцааг МХБ-д бүртгүүлэн хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсан. “Нако түлш” ХК нь жилд 40000 тн хагас кокс, 20000 тн брикет, 5000 тн коксын тос үйлдвэрлэх хүчин чадалтай.

## Компаний бүтэц, зохион байгуулалт



“Нако түлш” ХК нь 2007 оноос эхлэн хувьцаат компаний хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тухайн компаний эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал юм. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компаний үйл ажиллагааны стратегийн бодлогыг тодорхойлон ажиллаж байгаа бол компанийн гүйцэтгэх захирал нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллаж байна.

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн:**

1. Д.Даянбилгүүн –“БиДиСЕК”ХК-ийн гүйцэтгэх захирал
2. Б.Лхагвадорж –“БиДиСЕК”ХК-ийн тэргүүн дэд захирал
3. С.Пүрэвсүрэн – “БиДиСЕК” ХК-ийн дотоод албаны менежер
4. Ж.Бат - “Нако түлш” ХК-ийн гүйцэтгэх захирал
5. Б.Батцэцэг- “Нако түлш” ХК-ийн дэд захирал
6. James Passin – Firebird management хөрөнгө оруулалтын менежер
7. Milewski Anthony- Firebird management хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
8. Davidoff Nicholas - Firebird management хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
9. Б.Амарбаясгалан –“БиДиСЕК”ХК-ийн ерөнхий менежер

**Хянан шалгагч:**

1. Ж.Нямбилэг– “БиДиСЕК” ХК-ийн нягтлан бодогч

**Аудитын компани:**

- Компани нь 2008 онд “Коласт” ХХК-тай гэрээ байгуулан хараат бус аудитаар ажиллуулав.
- 2009 оны санхүүгийн тайланд “Далай ван” ХХК-тай гэрээ байгуулан аудит хийлгэсэн.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Жигжид овогтой Бат тус компанийн гүйцэтгэх захирлын албыг 2007 оноос хашиж байна. 1959 онд Архангай аймгийн Цэцэрлэг суманд төрсөн. Монгол Улсын Их Сургуулийг уул уурхайн инженер мэргэжлээр 1977 –ноос 1987 онд дүүргэсэн. ШУТИС –ийн Уул Уурхайн Инженерийн Сургууль төгсөж 2006 онд уул уурхайн зөвлөх инженер болсон.

Ажлын туршлага

- 1982-1986 онд Шарын голын уурхайд мастер, инженер
- 1987-1997 онд ШУТИС-ийн уул уурхайн тэнхимд эрдэм шинжилгээний ажилтан
- 1998-2008 онд Монгол-Оросын хамтарсан “УБИР” ХХК, “Голден Хаус” ХХК-д менежер
- 2000-2007 онд “Мөнхийн Оргил” ХХК-ийн захирал

## ТӨСЛИЙН ТУХАЙ

“Нако түлш” ХК нь нүүрсийг дулаан технологийн аргаар нам хэм /500-700 С/-д боловсруулан, нүүрсэнд агуулагдах хорт бодисыг хий байдлаар ялган авч үйлдвэрт хэрэглэгдэх хагас кокс, жижиг хэрэглэгч хэрэглэх утаагүй түлш болох брикет мөн коксын тос гэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх төслийг 2007 оноос хэрэгжүүлж байна.

Өнөөдрийн байдлаар хотын агаарын бохирдлын 91 хувийг гэр хороололд амьдарч буй 165 мянга гаруй айл өрхийн хэрэглэж буй 660 мянган тонн (1 жилд) түүхий нүүрсний утаанаас, 2,8 хувь нь автомашин, үлдсэн нь цахилгаан станцын утаа бүрдүүлдэг. Энэхүү агаарын бохирдлыг бууруулах хамгийн энгийн, хямд, боломжтой цорын ганц шийдэл нь одоогийн түлж байгаа түүхий нүүрсийг боловсруулж утаагүй түлш болгох явдал юм.

**<u>Нүүрс боловсруулалт</u>**



## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлж эхэлсэн огноо | 2007 оны 10-р сар |
| Төслийн гүйцэтгэлийн хувь | 82% |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын хэмжээ | 1`084 сая төгрөг |
| Firm commitment татан төвлөрүүлсэн | 900 сая төгрөг |
| Үүсгэн байгуулагчдын оруулсан зээл | 184 сая төгрөг |
| Төслийн гүйцэтгэлийн дутуу хувь | 18% |
| Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ | 542.8 сая төгрөг |
| Үйлдвэр угсралтын зардал | 47% |
| Эргэлтийн хөрөнгө нүүрсний нөөц | 53% |

"Нако түлш" ХК нь хагас коксын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг барьж, байгуулах төсөлд шаардлагатай 900 сая төгрөгийн санхүүжилтийг firm commitment хэлбэрээр өөрийн хувьцааг гарган арилжаалж татан төвлөрүүлсэн ба мөн үүсгэн байгуулагчдаас нэмэлт 184 сая төгрөгийн хүүгүй зээлийг оруулан үйлдвэрийн бүтээн босголтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгө нь үйлдвэрийн барилга байгууламж, үндсэн тоног төхөөрөмж зэрэгт зарцуулагдсан.

| **Зарцуулалт** | **Дүн мян.төг** | **Хувь** |
|---|---:|---:|
| Үйлдвэрийн тоног төхөөрөмж | 372 119,10 | 34,33% |
| Гаалийн татвар, НӨАТ | 67 216,20 | 6,20% |
| Үйлдвэрийн барилга | 229 120,30 | 21,13% |
| Үйлдвэрийн тоног төхөөрөмж /УТЗ/ | 170 766,80 | 15,75% |
| Эрчим хүчний шугам татах | 21 747,00 | 2,01% |
| Үйл ажиллагааны зардал | 79 083,10 | 7,29% |
| Авто машин | 49 087,80 | 4,53% |
| Бараа материал | 4 949,60 | 0,46% |
| Санхүүжилтын зардал | 90 000,00 | 8,30% |
| **Нийт дүн** | **1 084 089,90** | **100,00%** |

- ✓ 1'084'089 мян төгрөгөөр үйлдвэр угсралтын ажлын 82% нь гүйцэтгэгдсэн.
- ✓ Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн төлбөр 85% нь төлөгдөж, 15% нь үйлдвэр бүрэн угсрагдаж, үйлдвэрлэл тогтворжих үед төлөх нөхцөлтэй орж ирсэн.

“Нако” төслийг хэрэгжүүлэх явцад анх төвлөрүүлсэн хөрөнгө доорх хүчин зүйлсийн нөлөөгөөр хагас коксын үйлдвэр ашиглалтанд ороход хүрэлцээгүй. Үүнд:

1. Нако төслийг боловсруулсан 2007 онд юаний ханш 147 төгрөг байсан 2008 онд 200 төгрөг болж өссөн. Үйлдвэр худалдан авах гэрээг юаниар хийсэн тул ханшийн зөрүүнээс 60-аад сая төгрөгөөр төлбөр нэмэгдсэн,
2. Төгрөгийн ханшийн уналт, бараа материалын үнийн өсөлт сөргөөр нөлөөлсөн,
3. Анх хагас коксын үйлдвэрийг Налайх дүүрэгт байгуулахаар төлөвлөж тухайн газарт 65 сая төгрөгийн ажил хийгдсэн
4. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг Дархан -Уул аймаг руу нүүлгэн шилжүүлэхэд 6 сая төгрөгийн нэмэлт зардал гарсан
5. “Нако” төслийг боловсруулахдаа үйлдвэрийн байр, үйлдвэр ажиллах эхний сарын нүүрс худалдаж авах /290 сая төгрөгийн/ эргэлтийн хөрөнгийг тусгаагүй байсан




Эх сурвалж: Монгол банк, Голомт банк

Иймээс дээрхи шалтгаануудын улмаас нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон.

Нэмэлт санхүүжилтыг 2009 оны 9 сарын 8-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэж, үйлдвэрийн угсралтын ажлыг богино хугацаанд хийж дуусган, ашиглалтанд оруулахын тулд хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр нэмэлт санхүүжилтыг татан төвлөрүүлэх, андеррайтертай хамтран ажиллах гэрээ байгуулахыг тус тус зөвшөөрсөн ба нэмэлт санхүүжилт татахтай холбогдох эрхүүдийг ТУЗ-д олгосон болно. “Нако түлш ХК нь хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар хувьцаа эзэмшигчид мэдээлсэн билээ.

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ БУЮУ НЭМЖ ГАРГАЖ БУЙ ХУВЬЦАА

Үйлдвэрийн үлдсэн 18%-ийн угсралтын ажлыг гүйцэтгэхэд 236 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 290.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус шаардагдаж байсан.

| | Үйлдвэр угсралтын 2 сард хийгдэх ажил /зардал/ | Төлбөрийн дүн | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Эрчим хүчний шугам КТП | 25`600 | 4,72% |
| 2 | Эрчим хүчний хэрэглээ | 4`500 | 0,83% |
| 3 | Хятад мэргэжилтний зардал /Монголд авчрах/ | 11`424 | 2,17% |
| 4 | Тосон ба усан сан | 59`241,32 | 10,91% |
| | Бэхжилт | | |
| 5 | Цэвэр бохир усны шугам | 5`500 | 1,01% |
| 6 | Контор, үйлдвэрийн барилга, асфальтан талбай | 20`400 | 3,76% |
| 7 | Нүүрс, кокс цагаалах конвейер | 22`000 | 4,05% |
| 8 | Ачигч машины түрээс /нүүрс нөөцлөхөд ашиглах/ | 6`000 | 1,11% |
| 9 | Шатах тослох материал | 4`589,8 | 0,83% |
| 10 | Коксын зуух, шатдаг хийн байгууламж, цахилгаан цех /Хятад мэргэжилтэнгүүд гүйцэтгэнэ/ | 10`300 | 1,90% |
| 11 | Вагоноос нүүрс авах бункер /Дархан хөвөнгийн хуучин бункерыг сэргээж, ашиглалтанд бэлдэх/ | 14`000 | 2,58% |
| 12 | Нүүрс ангилан ялгах байгууламж /2,5-3 м өндөр төмөр хийц байгууламж/ | 6`850 | 1,26% |
| 13 | Хагас кокс ангилан ялгах байгууламж | 6`850 | 1,26% |
| 14 | Ажилчдын цалин, НДШ, цалингийн өглөг | 24`028,4 | 4,43% |
| 15 | 2009 оны эхний хагаст гарсан өглөг | 3`608,57 | 0,66% |
| 16 | ХХАА, хоол хүнс | 4`524 | 0,85% |
| 17 | Магадлашгүй ажлын зардал | 5`868.6 | 1,08% |
| 18 | Эргэлтийн хөрөнгө 1 сарын нүүрс бэлдэх | 290`360 | 53,49% |
| | **Дүн** | **526`644.69** | |
| 19 | Шимтгэл хураамжын зардал /Андеррайтер, МХБ, ҮЦТТТХТ/ | 17’220.21 | 3.17% |
| | **Нийт дүн** | **542’864,90** | **100%** |

Дээрхи шаардлагатай байгаа 542,864.90 мян.төгрөгийн нэмэлт санхүүжилтээс үүсгэн байгуулагчид 2010 оны 3 дугаар сард 181,240,570 төгрөгийн зээлийг хүүгүйгээр, үйлдвэр ашигтай ажиллах хүртэл тодорхойгүй хугацаагаар зээлдүүлсэн учраас нэмэлт хувьцаа гарган татах санхүүжилтын хэмжээ 370 000 000 төгрөг болж буурсан.

Нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээр “БиДиСЕК” ХК нь 2009 оны 9 дүгээр сарын 16-нд, “Эм И Ти ЭФ” ХХК нь 2009 оны 11 дүгээр сарын 2-нд тус тус хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулан нийт 99,735,550 төгрөгийг “Нако түлш” ХК-д зээлдүүлээд байна.

**Нэмэлт хувьцааны үнэ тогтоосон үндэслэл**

Монголын Хөрөнгийн Биржийн 2010 оны 8 сарын 25-ны өдрийн мэдээгээр “Нако түлш” ХК-ийн сүүлийн 6 сарын дундаж ханш 229 төгрөг байгааг үндэслэн Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 4-т *нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо Хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно* гэж заасны дагуу 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн СЗХ –ны 235 тоот тогтоол, “Нако түлш” ХК-ийн 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн ТУЗ-ын 1 тоот тогтоолоор тэргүүн ээлжинд худалдах авах эрхээ хэрэгжүүлэх үнэ, нийтэд нээлттэй худалдагдах хувьцааны нэг бүрийн үнийг **229** төгрөгөөр тогтоож байна.

**Нэмэлт хувьцааны задаргаа:**

| Нэмэлт хувьцааны задаргаа | Үнийн дүн | Хувьцааны тоо |
|---|---|---|
| Нэмэлт хувьцааны нэг бүрийн худалдах үнэ | 229₮ | |
| Нэмэлт хувьцааны санхүүжилт | 370,000,109₮ | |
| Нэмэлт хувьцааны нийт тоо ширхэг | | 1,615,721 |
| **Олон нийтэд санал болгож буй хувьцаа** | **270,264,655₮** | **1,180,195** |
| **Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу /хувьцаанд хөрвөх/** | **99,735,454₮** | **435,526** |

**Санамж:** Хувьцаа эзэмшигч нэг бүр нь 229 төгрөгийн үнэ бүхий нийтэд санал болгож буй 1,180,195 ширхэг хувьцаа, хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу хувьцаанд хөрвөж буй 435,526 ширхэг хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжин худалдан авах эрхтэй.

Хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж буй хувьцааны 14,68%-тай тэнцэх хэмжээний хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгож байна.

**Хувьцаанд хөрвөх зээл, энгийн зээл**

Тус компани нь нэмэлт санхүүжилт татахаар шийдвэрлэснээс хойш одоогоор “Бидисек” ХК-иас 74,735,550 төгрөгийг, “Эм И Ти Эф” ХХК-иас 25,000,000 төгрөгийг, үүсгэн баййгуулагчидаас 181,240,570 төгрөгийг тус тус зээлээд байгаа ба нийт зээлийн дүн нь 280,976,120 төгрөг болоод байна.

| № | Нэрс | Зээлийн хэмжээ | Хувьцаанд хөрвөх эсэх | Өрийг хувьцаагаар солих хувьцааны тоо | Үндэслэл, тогтоол, шийдвэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үүсгэн байгуулагчид | 181,240,570 | Үгүй | - | |
| 2 | “БиДиСЕК”ХК | 74,735,550 | Тийм | 326,356 | 2009.09.08-ны ХЭХ тогтоол №1, 2009.09.15-ны ТУЗ тогтоол №1,2,3 Гэрээ 2009.09.16 |
| 3 | “METF”ХХК | 25,000,000 | Тийм | 109,170 | 2009.09.08-ны ХЭХ тогтоол №1, 2009.09.15-ны ТУЗ тогтоол №1,2,3 Гэрээ 2009.11.02 |
| | Хувьцаанд хөрвөх нийт дүн | **99,735,550** | | | |
| | Хувьцаанд хөрвөх нийт ширхэг | | | **435,526** | |

Уг зээлийн хөрөнгөөр үйлдвэрийн угсралтын ажлуудыг хийж гүйцэтгээд байна. “Нако түлш” ХК-ийн Хагас коксын үйлдвэрийн угсралтын ажлыг 2010.04.01-нээс эхлүүлэхээр төлөвлөж байсан боловч цаг агаарын хүйтрэлтээс шалтгаалан төлөвлөсөн хугацаанаас 20 хоногоор хоцорч эхэлсэн. Гэвч шуурхай ажилласны үр дүнд доорхи ажлуудыг хийж дуусгаад байна. Үүнд:

- Усан сан, тосон сангийн байгууламжын бетон цутгалтын ажил
- Оффисын барилга
- Цахилгаан шит операторын байр
- Худгийн барилга
- Эрчим хүчний шугам татах
- Нүүрс цагаалах конвейер
- Коксын зуух, шатдаг хийн байгууламжын угсралтын ажлыг БНХАУ-ын мэргэжлийн ажилчдаар хийж гүйцэтгүүлээд байна.

“Нако түлш” ХК нь 9 дүгээр сарын тоног төхөөрөмжийн зүгшрүүлэлт, технологийн горимыг тогтворжуулах үүднээс хагас үйлдвэрийн туршилтын хэлбэрээр ажиллаж эхлэх бөгөөд 10 дугаар сараас үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулахаар зорилт тавин ажиллаж байна.

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭЛ



NR-3200 маркын коксын зуух



Эрчим хүчний шугам КТП барьж 400 квт-ын цахилгаан эрчим хүчинд холбогдсон.



Тосон болон усан сангийн




Шатдаг хийн байгууламж




Оффисын барилга, цахилгааны шит, операторын байр

**Төслийн ач холбогдол**

Нүүрсийг боловсруулан утаагүй түлш үйлдвэрлэснээрээ боловсруулаагүй нүүрсний хэрэглээг багасган, экологид ээлтэй үйлдвэр байгуулснаараа энэ төсөл нь олон талын ач холбогдолтой.

- Төсөл нь Green IPO хөдөлгөөний дагуу гарч ирж хөрөнгө оруулагчдад байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж байгаа,
- Утаа үнэргүй, хөө тортоггүй түлшийг хэрэглэснээрээ төв суурин газрын агаарын бохирдлыг багасгах,
- Зах зээлд шинэ эрэлт хэрэгцээг бий болгож, гэр хороололын айл өрхүүд хагас кокс, шахмал түлшийг хэрэглэснээрээ бага хэмжээтэй, өртөг багатай түлшээр хэрэгцээгээ хангаж, цэвэр шинэ орчин бий болох,
- Үндэсний зарим барилгын материалын болон төмөрлөг боловсруулах үйлдвэрүүдэд илчлэг өндөртэй хямд үнэтэй түлшээр хэрэгцээгээ хангах боломж бий болно,
- Улсын болон орон нутгийн төсөвт орох хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ



- Хот орчмын агаарын бохирдлыг бууруулах гарц нь утаагүй түлшний хэрэглээ ба Хотын захиргаанаас боловсруулаагүй нүүсний хэрэглээг хязгаарлаж, зах зээлд утаагүй түлшний эрэлт хэрэглээ нэмэгдэж байна.
- Хэдийгээр шахмал түлшний жижиг үйлдвэрүүд ажиллаж эхлээд байгаа ч тэр бүр нийт зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангахгүй, бүтээгдэхүүний чанар зохих стандартад хүрэхгүй байгаагийн улмаас өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэмжээнд хүрээгүй байна, ,
- Улаанбаатар хотод гэр хорооллын 165`000 өрх байгаа ба өрх бүр жилд дунджаар 4 тонн түүхий нүүрсийг 1 тонн-ыг нь 60`000 төгрөгөөр худалдан авч хэрэглэдэг ба нийт хэрэглээ нь 39,6 тэрбум төгрөгийн 660 мянган тонн нүүрс болж байна. Дээрх хэрэглээг хагас кокт шилжүүлэхэд 26,4 тэрбум төгрөгийн 330 мянган тонн хагас кокс болно.

**Үйлдвэрийн байршил, дэд бүтэц**

- Үйлдвэр нь Дархан Уул аймгийн үйлдвэрийн дүүрэгт байрладаг бөгөөд тус дүүрэгт Монгол орны барилгын материал төмөрлөгийн үйлдвэрүүд төвлөрсөн.
- Үйлдвэр нь Дархан Уул аймагруу шилжсэнээр түүхий эд, төмөр зам, бүтээгдэхүүний зах зээл, гол хэрэглэгчиддээ ойртож, үйлдвэрийн тогтмол зардлыг бууруулах боломжтой болсон.

## ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ

| ***Жилд боловсруулах нүүрсний хэмжээ:*** **100`000 тн** | | | | |
|---|---|---|---|---|
| **Бүтээгдэхүүний гарц** | | | | |
| Хагас кокс | 60% | | | |
| Брикет | 30% | | | |
| Коксын тос | 5% | | | |
| Хаягдал | 5% | | | |
| **Эцэсийн бүтээгдэхүүн** | **тонн** | **Бүтээгдэхүүн өртөг** | **Дотоод зах зээлийн үнэ төгрөг** | **Гадаад зах зээлийн үнэ Хятад** |
| **Хагас кокс** | 40`000 | 59`646 | 80`000 | 287`000 |
| **Брикет** | 20`000 | 55`154 | 90`000 | 282`000 |
| **Коксын тос** | 5`000 | 232`637 | 361`000 | 389`500 |
| **Шатдаг хий** | 30`000 | Үйлдвэрийн дотоод хэрэгцээнд | | |

"Нако түлш" ХК нь жилд 100000 тн нүүрсийг боловсруулан 40000 тн хагас кокс, 20000 тн брикет, 5000 тн коксын тос үйлдвэрлэнэ.Хагас кокс, брикетэн түлшийг дотоодын зах зээлд борлуулахаар төлөвлөж байгаа бол коксын тосыг Хятад улс руу экспортлон худалдана

Төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоог тооцоолохдоо хагас кокс, брикетэн түлшийг дотоодын зах зээлд борлуулахаар тусгасан. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бүгдийг 100% Хятад улс руу экспортловол үйлдвэрийн жилийн борлуулалтын орлого 19 тэрбум төгрөг байхаар байна.

| | **Үр ашгийн тооцоо /сая. төгрөгөөр/** | **1 дэх жил** | **2 дах жил** | **3 дах жил** | **4 дэх жил** | **5 дах жил** |
|---|---|---|---|---|---|---|
| | **хөрөнгө оруулалтын дүн** | **1810** | | | | |
| 1 | Борлуулалтын орлого | 3,790 | 7,579 | 7,579 | 7,579 | 7,579 |
| 2 | Үйл ажиллагааны зардал | 2,820 | 5,639 | 5,639 | 5,526 | 5,526 |
| 3 | Үйл ажиллагааны ашиг | 970 | 1,940 | 1,940 | 2,053 | 2,053 |
| 4 | Дахин санхүүжилтын зардал | 112 | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | Үйлдвэрийн техник тоног төхөөрөмж | 62 | 31 | 0 | 0 | 0 |
| 6 | Татварын өмнөх ашиг | 796 | 1,909 | 1,940 | 2,053 | 2,053 |
| 7 | Татварын зардал | 80 | 191 | 194 | 205 | 205 |
| 8 | Татварын дараах ашиг | 717 | 1,718 | 1,746 | 1,848 | 1,848 |
| | Нийт хувьцаа /сая ширхэг/ | 12,85 | 12,85 | 12,85 | 12,85 | 12,85 |
| | EPS | 56 | 134 | 136 | 144 | 144 |
| | ROI | 40% | 105% | 104% | 102% | 102% |
| | ROE | 56% | 134% | 136% | 144% | 144% |

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ, ХУВЬЦААНЫ ЭРГЭЛТ

“Нако түлш” ХК нь 2007 онд 11 сарын 29-нд 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11 сая ширхэг хувьцааг СЗХ бүртгүүлсэн билээ.

- 2010 оны 3 сарын 31-ний байдлаар нийт 104 хувьцаа эзэмшигчтэй байна.
- Нийт хувьцаанаас 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг харуулвал:

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо ширхэг | Нийт хувьцаанд эзлэх хувь |
|---|---|---|
| Firebird Global Master Fund | 3’305’000 | 30% |
| Firebird Global Master Fund II | 2’685’000 | 24.41% |
| “Эм И Ти Эф” ХХК | 1’000’000 | 9.09% |
| Firebird Mongolia fund | 880’000 | 8% |
| “БиДиСЕК” ХК | 1,864,528 | 16.95% |

Хувьцааны арилжаалагдсан байдал болон үнийн хэлбэлзэлийг графикаас харна уу.




"Нако түлш" ХК-ийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 2008 оны 7 сарын 14 өдөр эхэлсэн. Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 2009 оны 9 сарын 15-ны өдөр хүртэл нийт 5'741022 ширхэг буюу 52.19%, 2010 оны 3 сарын 23-ны өдөр хүртэл нийт 7'888'689 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 71.72% нь арилжаалагдсан байна. Нийт арилжаалагдсан хувьцааны дундаж ханш нь 238 төгрөг, доод үнэ 115 төгрөг, дээд үнэ 300 төгрөг байна. Өдрийн дундаж гүйлгээ нь 16,7 сая төгрөг, сарын дундаж гүйлгээ нь 79,3 сая төгрөг байлаа.

## Бусадтай байгуулсан гэрээ, хэлцлүүд

| | |
|---|---|
| Хятад улсын Жи Нан хотын нүүрсний хийн бүтээгдэхүүний үйлдвэртэй 2008 оны 1 сарын 22-нд үйлдвэр худалдаж авах гэрээ | NR-3200 маркын хагас кокс, шатдаг хийн зуух 2 комыг нэг бүрийг 1445 мянган юанаар худалдан авахаар гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж орж ирж угсралтын ажил хийгдэж дуусаад байна. Үйлдвэрийн төлбөрийг 5 үетэйгээр төлөхөөр гэрээнд заасан ба одоогоор үйлдвэрийн төлбөрийн 85%-ийг төлөөд байгаа ба үйлдвэрийг хүлээлгэн өгөхөд 10%-төлнө, Үлдэгдэл 5%-ийг баталгаат хугацаа дууссаны дараа төлбөрийг төлнө. Баталгаат хугацаа нь ашиглалтанд орсноос хойш 1 жил. |
| Нийслэлийн агаарын чанарын албатай байгуулсан 2009 оны 7 сарын 21-ний өдрийн гэрээ | Улаанбаатар хотын гэр хорооллын айл, өрхөд коксон түлш нийлүүлэх гэрээг байгуулсан. Жилд 30000 тн өндгөн шахмал түлш /брикет/ үйлдвэрлэн нийлүүлэх |
| Мон Эко Тур ХХК-тай хагас коксын усан сан, тосон сангийн барилга, угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр байгуулсан 2009 оны 8 сарын 31-ний гэрээ | Дархан –Уул аймагт байршилтай 875 ам.метр талбайтай, 4200 шоо метр эзэлхүүнтэй барилга угсралтыг гүйцэтгүүлэхээр нийт ажлын хөлс 14 сая төгрөг байхаар тохиролцон гэрээ байгуулсан. Тосон сан, усан сангийн бетон цутгалтын ажил дууссан акт үүлдэн хүлээж аваад байна. |
| БиДиСЕК ХК-тай 2009 оны 9 сарын 11-нд байгуулсан Хамтран ажиллах гэрээ | Энэ гэрээгээр “Нако түлш” ХК-ийн үйлдвэрийн угсралтын ажлыг дуусган, үйлдвэрийг ашиглалтанд оруулах, эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэхэд шаардлагатай байгаа нэмэлт санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд зуучлахаар гэрээг байгуулав. Нако түлш ХК нь андеррайтерын үйлчилгээний хөлсөнд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 5%-д үйлчилгээний хөлс төлөхөөр харилцан тохиролцож хамтран ажиллаж байна. |
| БиДиСЕК ХК-тай 2009 оны 9 сарын 16-нд хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ | Нако түлш ХК-ийн нэмэлт санхүүжилтыг хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр татан төвлөрүүлэх ТУЗ-ын 2009 оны 9 сарын 15-ны өдрийн №1 тоот тогтоолын үндэслэн “БиДиСЕК” ХК –тай 74,735,550 төгрөгийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулан 74,735,550 төгрөгийг зээлээд байна. Энэхүү санхүүжилтээр шатдаг хийн байгууламжын |

| | |
|---|---|
| | угсралтын ажил, эрчим хүчний шугам татах, гүний худаг гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. |
| Эм И Ти Эф ХХК-тай 2009 оны 11 сарын 2-нд байгуулсан хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ | Нако түлш ХК-ийн нэмэлт санхүүжилтыг хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр татан төвлөрүүлэх ТУЗ-ын 2009 оны 9 сарын 15-ны өдрийн №1 тоот тогтоолын үндэслэн “Эм И Ти Эф” ХК –тай 91,660,800 төгрөгийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулсан ба үүнээс 25,000,000 төгрөгийн зээлэн авч угсралтын ажилд ашиглаад байна. |
| “Шарын гол ХК –тай 2010 оны 4 сарын 5-нд хамтран ажиллах санамж бичиг зурсан | Энэхүү санамж бичгээр түүхий эд болох нүүрсийг 2 тал харилцан тохиролцож үнэ ханшыг тогтооно мөн нийлүүлэгч тал худалдан авагч талд жилд 120 мянган тонн хүртэлх хэмжээний УСТ-1089-90 стандартын шаардлагад тохирсон 50-300 мм-ийн технологийн нүүрсийг тогтмол нийлүүлнэ гэж заасан байна. |
| “Дархан өртөө-2” өртөөний “Дархан хөвөн ”ХК-ийн салбар замд хийгдэх их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр 2010 оны 6 сарын 11-ны өдөр гэрээ байгуулсан. | “Нако түлш” ХК болон УБТЗ-ын Дархан дах төмөр замын 1-р ангитай 2010 оны 6 сарын 11 өдөр “Дархан хөвөн” ХК-ын салбар төмөр замд их засвар үйлчилгээ хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээг байгуулан ажлыг гүйцэтгүүлснээр салбар төмөр замыг сунгахад дөхөм болж төмөр замаар түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэх бүрэн боломжтой болж байгаа юм. |

## ЭРСДЭЛ

“Нако түлш” ХК -ийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг худалдаж авахдаа хөрөнгө оруулагч та үйлдвэрийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй дараах эрсдлүүдийг анхааран үзэж хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу. “Нако түлш ” ХК нь үйл ажиллагааныхаа явцад доорх эрсдлүүдтэй тулгарч болзошгүй юм.

- Зах зээлийн эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Бусад эрсдэл

**Зах зээлийн эрсдэл :**

- Макро эдийн засгийн нөлөөлөл, инфляци
- Татварын эрсдэл,
- Түүхий эдийн үнэ ханшийн өсөлт,
- Бүтээгдэхүүний үнэ ханшийн бууралт,
- Харилцагч байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалсан хүндрэл учрах
- Валютын ханшийн өөрчлөлтийн болзошгүй эрсдлийг үнэлж тооцох шаардлагатай. Зах зээлийн эрсдлийн урьдчилан таамаглах төвөгтэй учир үнэ, ханшийн талаар тогтмол судалгаа хийж байх хэрэгтэй. Мөн түүхий эд нийлүүлэгч, бүтээгдэхүүний хэрэглэгчтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж эрсдлийг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой.

**Үйл ажиллагааны эрсдэл:**

Үйлдвэрт дараах эрсдэл учирч болзошгүй гэж төсөөлж байна:

- Техник, тоног төхөөрөмжийн эвдрэл
- Нүүрс нийлүүлэгч талаас шалтгаалах түүхий эдийн хомсдол
- Түүхий эдийн чанар
- Үйлдвэрийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах /түүхий эдээр тогтмол хангах/

- Үйлдвэр нь Монголд анх удаа нүүрсийг их хэмжээгээр дулаан технологийн аргаар боловсруулж хагас кокс үйлдвэрлэх тул боловсон хүчний туршлага дутах, мэргэжлийн алдаа гарах
- Үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөн ажиллах /Үйлдвэрийн осол/
- Эрүүл мэнд – хамгаалал, хувь хүний бэртэл гэмтэл
- Бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүний чанар
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тээвэрлэлт, хүргэлтийн алдаа, тээвэрлэлтын зардал
- Түлш шатахууны үнийн өсөлт
- Галын аюул

Эдгээр эрсдлүүдийг бууруулах зорилгоор доорхи үйл ажиллагааг авч явуулна.

- Үйлдвэр ашиглалтанд орсны эхний саруудад 1-2 Хятад мэргэжилтэнг гурав гурван сараар зөвлөх мэргэжилтнээр ажиллуулах, ажилтнуудад сургалт зохион байгуулах, Хятад улсад ажилтнуудыг дадлага хийлгэх. 2010 оны 4 дүгээр сард 1 инженер, 2 ажилтанг Хятад улсын хагас коксын үйлдвэрт 7 хоногийн дадлага хийлгэсэн.

- Үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар технологийн горимыг Хятад улсын мэргэжилтнүүдтэй хамтран Монгол хэл рүү хөрвүүлэн орчуулаад ажилтнуудад ажиллах зааварчилгааг бэлдэж байна.
- Түүхий эдийг болох нүүрсийг Шарын гол ХК-ийн уурхайгаас авахаар нүүрс худалдан авах санамж бичигт гарын үсэг зураад байна. “Шарын гол” ХК-аас нүүрс худалдан авахаар гэрээ байгуулснаар түүхий эдийн нөөцийн хомсдолд орох эрсдлийг багасгаж үйлдвэрийн үйл ажиллагаа тогтвортой жигд ажиллах бүрэн боломжтой болж байна. Мөн түүхий эдийн хоёрдогч эх үүсвэр судлан гэрээ хэлэлцээр хийх,

- Галын байгууллага, даатгалын байгууллагуудтай хамтарч ажиллах, даатгуулах бололцоог судлах,

- Түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэлт үүсэх хорогдол, тээвэрлэлтийн зардлыг багасгахаар “Дархан Хөвөн” ХК-ийн төмөр замыг сунган үйлдвэрээс шууд ачих, буулган түүхий эд, бүтээгдэхүүнийг хорогдол багатай тээвэрлэхээр төмөр замыг

сунгах ажлыг хийхээр УБТЗ-тай төмөр замын засвар, арчилгаа хийлгэх, сунгах ажлыг хийлгэхээр гэрээ байгуулаад байна.

- Монгол улсад коксын тосыг ашигладаг үйлдвэр байхгүй тул Нако түлш ХК нь коксын тосыг Хятад Улс руу импортлоно. Коксын тосыг тээвэрлэхдээ бид хөлдөөж чанарыг муудахгүйн тулд тусгай цамцтай вагоноор тээвэрлэх тул УБТЗ-тай вагон ашиглалтын талаар гэрээ байгуулан ажиллах

- Бүтээгдэхүүний гарч, бүтээгдэхүүний чанарт өөрчлөлт оруулахын тулд түүхий эдийг найдвартай, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, олборлолтыг нэг дороос гаргаж буй уурхайгаас авах .

- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах хамгийн чухал зүйл бол байнгын сургалт, ухуулга болон зааварчилгаа өгөх явдал билээ. Өдөр тутмын болон сарын бүрийн давтан зааварчилгааг хуваарийн дагуу байнга өгнө. Тоног төхөөрөмжийг тогтмол шалган тохируулах, ерөнхий хуваарийг чанд мөрдөн ажилласнаар тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарахгүй байж үйл ажиллагаа хэвийн явагдана.

**<u>Бусад эрсдэл:</u>**

- Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл**:** Байгалийн гэнэтийн үзэгдлүүд нь компанийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжид гэмтэл, бэртэл, эрсдэл учруулах боломжтой ба үүнээс гарах эрсдэл, засвар зэрэгт зарцуулсан хөрөнгө нь компанийн санхүүгийн үзүүлэлтэнд муугаар нөлөөлөх талтай.

## ХУВЬЦАА ХЭРХЭН ХУДАЛДАН АВАХ БЭ?

“Нако түлш” ХК нь үйлдвэрийн угсралтын ажлыг дуусган ашиглалтанд оруулах, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхээр нэг бүр нь 229 төгрөгийн үнэтэй 1,615,721 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж байна.

Нэмж гаргаж буй энгийн хувьцааг доорхи байдлаа нийтэд санал болгож байна.

- “БиДиСЕК”ХК, “Эм И Ти Эф” ХХК-ийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу оруулсан нийт 99,735,550 сая төгрөгийн зээлийг нэг бүр нь 229 төгрөгийн үнэтэй 435,526 ширхэг хувьцаанд хөрвүүлэх
- Нийтэд нээлттэй худалдагдах 1,180,195 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 229 төгрөгөөр нийтэд худалдах.

| | Ажлын дараалал | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр | 2010 оны 8 сарын 25-ны 235 тоот тогтоол |
| 2 | Монголын Хөрөнгийн Биржийн шийдвэр гарах | Ажлын 30 хоног |
| 3 | Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа | 2010 оны 8 сарын 25-ны өдрөөс 2010 оны 10 сарын 6-ны өдрийг дуустал ажлын 30 хоног |
| 4 | МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжих | Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ажлын 30 хоногийн хугацаа дууссаны дараа |

2009 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэх өдөр буюу 2009 оны 8 сарын 12-ны өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуулийн 35.1.4 болон 39 дүгээр зүйлд заасны дагуу нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхдээ харьяа брокер, дилерийн компанидаа захиалга өгч, хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх мэдэгдэл, хувьцааны үнийг төлсөн баримт хамт “Нако түлш” ХК-д ирүүлнэ.
- Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны арилжаа хоёрдогч зах зээлийн арилжаанаас тусдаа зохион байгуулагдана.
- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар мэдэгдээгүй нөхцөлд тухайн хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсанд тооцож, хувьцааг МХБ-аар нийтэд санал болгон худалдан борлуулна.
- Нэмэлт хувьцааны талаар дэлгэрэнгүй мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон хөрөнгө оруулалтын зөвлөх, Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСЕК ХК-ээс мөн www.bdsec.mn, www.naco.mn, www.mse.mn сайтуудаас авч болно.

## АНДЕРРАЙТЕР

1991 онд Төв аймгийн иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх зорилгоор Баяндөхөм брокерийн пүүс анх байгуулагдсан.

1995 онд хөрөнгийн зах зээлд брокер, дилерийн иж бүрэн үйл ажиллагаа явуулахаар "БиДиСЕК"ХХК нь болон өөрчлөн зохион байгуулагдсан.

2005 онд БиДиСЕК ХК нь Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан.

БиДиСЕК компани нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн "БиДиСЕК" ХК болж 2006 оны 6 сарын 23-нд олон нийтэд хувьцаагаа санал болгон арилжаалсан.

2007 онд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагааг цогцоор нь үзүүлж буй цорын ганц компани болсон.

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 13 хувьцаат компани шинээр болон нэмж хувьцаа гарган арилжаалсан ба БиДиСЕК ХК 8 хувьцаат компанийн андеррайтераар ажилласан байна.

**Гүйцэтгэсэн IPO**

| Хувьцааны | Бондын |
|---|---|
| • "Монгол Шилтгээн" ХК<br>• "Женко Тур Бюро" ХК<br>• "БиДиСЕК" ХК<br>• "Монинжбар" ХК<br>• "Хай Би Ойл" ХК<br>• "Нако түлш" ХК<br>• "Туул Сонгино" ХК<br>• "Хөх ган" ХК | • "Пума" ХХК-ийн Пума бонд<br>• "Монинжбар" ХК-ийн Бүтээн байгуулалт бонд<br>• "Нийслэл өргөө" ХК-ийн Нийслэл өргөө бонд |

"Нако түлш" ХК-ийн 2009 оны 9 сарын 8-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлын 2 тоот тогтоолыг үндэслэн андеррайтерын гэрээг байгуулсан."БиДиСЕК" ХК нь "Нако түлш" ХК-ийн үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдаж буй санхүүжилтыг татах буюу нэмэлт хувьцааг боруулах нөхцөлтэй ба ажлын гүйцэтгэлээс буюу нийт татан төвлөрүүлсэн санхүүжилтын мөнгөн дүнгээс 5%-ийн андеррайтерын үйлчилгээний хөлс авахаар гэрээг байгуулан ажиллаж байна.

Регистрийн дугаар 4489969

А

**НАКО ТҮЛШ ХХК-ний**
**2007..оны..4-р улиралын**
**санхүүгийн тайлан**

| Хянаж хүлээн авсан | Сар өдөр | Гарын үсэг |
|---|---|---|
| Санхүүгийн хэлтэс | 28/II | |
| Татварын хэлтэс | 28/II | |
| Статистик ийн хэлтэс | 28/II | |
| НДХэлтэс | 1/28 2008 | |

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДИСЕК"
ХК
ТТА4467 ≥ 2053482

НАКОТҮЛШ
ХК

62

**НАКО ТҮЛШ ХХК** **БАЛАНС**

2007.10.1

Аж ахуйн нэгжийн нэр /Төгрөгөөр /

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1 дүгээр сарын 1 | 12 дугаар сарын 31 |
| А | Б | 1 | 2 |
| 1 | **Хөрөнгө** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | | 186774661.8 |
| 1.1.2 | Богино хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.1.3 | Үнэлгээний хасагдуулга | | |
| 1.1.4 | Дансны авлага | | 44591151 |
| 1.1.5 | Найдваргүй авлагын хасагдуулга | | |
| 1.1.6 | Бусад авлага | | |
| 1.1.7 | Бараа материал | | 12636000 |
| 1.1.8 | Мал амьтад | | |
| 1.1.9 | Урьдчилж төлсөн тооцоо | | |
| 1.1.10 | | | |
| 1.1.20 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | 244001812.8 |
| 1.2 | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | | |
| 1.2.2 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.3 | Бусад үндсэн хөрөнгө | | |
| 1.2.4 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.5 | Дуусаагүй барилга | | 28000000 |
| 1.2.6 | Мал амьтад/ХАА-н үйлдвэрлэлийн/ | | |
| 1.2.7 | Биет бус хөрөнгө | | 204488000 |
| 1.2.8 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.9 | Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | |
| 1.2.10 | Үнэлгээний хасагдуулга | | |
| 1.2.11 | | | |
| 1.2.20 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | 232488000 |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **476489812.8** |
| 2 | **Өр төлбөр эзэмшигчдийн өмч** | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | |
| 2.1.1.3 | Орлогын татварын өглөг | | |
| 2.1.1.4 | ХАОАТ-ын өглөг | | |
| 2.1.1.5 | НӨАТ-ын өглөг | | |
| 2.1.1.6 | Бусад татварын өглөг | | |
| 2.1.1.7 | ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | | |
| 2.1.1.8 | Мөнгөн ноогдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.9 | Банкны богино хугацаат зээл | | |
| 2.1.1.1.0 | Бусад өглөг/Хувь хүнээс авсан зээл | | |

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ХК
ТТА4467 ☎ 2052482

НАКО ТҮЛШ ХК
ТТГ3516 ☎ 4489969

65

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.1.11 | Урьдчилж орсон орлого | | |
| 2.1.1.12 | | | |
| 2.1.1.20 | Богино хугацаат өглөгийн дүн | | |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат векселийн өглөг | | |
| 2.1.2.2 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.3 | Урт хугацаат бондын өглөг | | |
| 2.1.2.4 | *Бусад урт хугацаат өглөг* | | |
| 2.1.2.5 | Урт хугацаат өглөгийн хасагдуулга | | |
| 2.1.2.6 | | | |
| 2.1.2.20 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | |
| **2.2.20** | **Өр төлбөрийн нийт дүн** | | |
| 2.3 | **2.Эзэмшигчидийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: а/ төрийн | | |
| 2.3.2 | *б/ хувийн* | | |
| 2.3.3 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.4 | **Хувьцаат капиталын дүн** | | 488500009.8 |
| 2.3.5 | Нэмэж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Дахин үнэлгээний нөөц | | |
| 2.3.7 | Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | | 2780000 |
| 2.3.8 | Хуримтлагдсан ашиг /алдагдал / | | -14790197 |
| 2.3.8.1 | *Тайлангийн үеийн* | | |
| 2.3.8.2 | Өмнөх үеийн | | |
| 2.3.20 | **Эзэмшигчийн өмчийн дүн** | | 476489812.8 |
| 2.4 | Үүнээс: Цөөнхийн хувь оролцоо | | |
| 2.5.20 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН** | | **476489812.8** |

УЛААНБААТАР ХОТ НАКО ТҮЛШ ХК

Захирал /Ж. Бат /

НАКО ТҮЛШ ХК САНХҮҮ

Ня-бо /Ч.Баатархүү /

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ХК ТТА4467 2052482

НАКО ТҮЛШ ХК ТТГ3516

64

**ОРЛОГЫН ТАЙЛАН**

**НАКО ТҮЛШ ХХК** **2007 оны 12 дугаар сарын 30 өдөр**

/Аж ахуйн нэгжийн нэр / / төгрөгөөр /

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1.1 | **Үндсэн үйл ажиллагааны орлого** | | |
| 1.1.1 | Борлуулалтын орлого | | |
| 1.1.2 | Борлуулалтын хорогдол ба буцаалт | | |
| 1.1.3 | Борлуулалтын хөнгөлөлт | | |
| **1.1.20** | **Борлуулалтын орлогын дүн** | | |
| ***1.2*** | ***Борлуулсан бүтээгдэхүүний өртөг*** | | |
| **1.3** | **Нийт ашиг** | | |
| **1.4** | **.Үйл ажиллагаа /Борлуулалт, Ерөнхий удирдлага/-ны зардал** | | |
| 1.4.1 | Үндсэн болон нэмэгдэл цалин | | 1440000 |
| 1.4.2 | Нийгмийн даатгалын шимтгэл | | 273600 |
| 1.4.3 | Засвар үйлчилгээний зардал | | 628600 |
| 1.4.4 | Ашиглалтын зардал | | |
| 1.4.5 | Түрээсийн зардал | | |
| 1.4.6 | Албан томилолтын зардал | | 1806633 |
| 1.4.7 | Тээврийн зардал | | |
| 1.4.8 | Түүхий эд материалын зардал | | |
| 1.4.9 | Элэгдлийн зардал | | |
| 1.4.10 | Зар суртачилгааны зардал | | |
| 1.4.11 | Шуудан холбооны зардал | | 647600 |
| 1.4.12 | Шатахууны зардал/түлш / | | 895650 |
| 1.4.13 | Найдваргүй авлагын зардал | | |
| 1.4.14 | Шагнал урамшууллын зардал | | 382100 |
| 1.4.15 | Зээлийн хүүгийн зардал | | |
| 1.4.16 | Бусад зардал | | 9295570 |
| 1.4.20 | **Үйл ажиллагааны зардлын дүн** | | 15369753 |
| **1.5** | **Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/** | | |
| ***2*** | ***Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)*** | | ***579556*** |
| 2.1 | Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал | | |
| 2.2 | Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал) | | |
| 2.3 | Ногдол ашгийн орлого | | |
| 2.4 | Валютийн ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг /алдагдал/ | | |
| 2.5 | Валютийн ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг /алдагдал/ | | |
| 2.6 | Хувьцаа, бондын зардлын хорогдол | | |
| 2.7 | Хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон ашиг | | |
| 2.8 | Бусад | | |
| 2.2 | **Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн** | | -14790197 |
| 3 | **Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/** | | -14790197 |
| 3.1 | Орлогын татварын зардал | | |
| 4 | **Татварын дараах ашиг /алдагдал/** | | |
| 4.1 | Цөөнхөд ноогдох хувь | | |
| *5* | ***Ердийн ажиллагааны ашиг /алдагдал/*** | | |
| 5.1 | Онцгой шинжтэй зүйлс- цэвэр | | |
| *6* | ***Тайлант үеийн цэвэр ашиг / алдагдал /*** | | -14790197 |
| | | | |
| 6.1 | Нэгж хувьцааны ногдол ашиг /алдагдал / | | 27.28 |

**Захирал** ____________ **-/ Ж. БАТ /**

**Ня-бо** ____________ **/ Ч.Баатархүү /**

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ХК
ТТА4467 2052482

НАКОТҮЛШ ХК

66

Сангийн сайдын 2006
оны 68 тоот
тушаалаар батлав

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**НАКО ТҮЛШ ХХК**
/Аж ахуйн нэгжийн нэр/

**2007 оны 12 сарын 31 өдөр**
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажилгааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | **Үндсэн үйл ажилгааны мөнгөн орлого** | | |
| 1.1.1 | Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө | | |
| 1.1.2 | Туслах үйл ажилгаанаас олсон мөнгө | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| 1.1.4 | Хүүгийн орлого | 579556 | |
| 1.2 | **Үндсэн үйл ажилгааны мөнгөн зарлага** | -72596904 | |
| 1.2.1 | Ажиллагчдад олгосон мөнгө | **1440000** | |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 408600 | |
| 1.2.3 | Түүхий,эд материал худалдан авахад төлсөн мөнгө | 12636000 | |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 647600 | |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 1524250 | |
| 1.2.6 | Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө | 44591151 | |
| 1.2.7 | Төлсөн хүү | | |
| .8 | Төлсөн орлогын татвар | 74500 | |
| .9 | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | | |
| 1.2.10 | Бусад | 11274803 | |
| 1.2 | **Үндсэн үйл ажилгааны цэвэр мөнгөн гүйлгээ** | -72017348 | |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | | |
| 2.2 | Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | | |
| 2.3 | . Худалдсан хөрөнгө оруулалтын орлого /+/ | | |
| 2.4 | Худалдаж авсан хөрөнгө оруулалт /-/ | -32488000 | |
| 2.5 | Хүлээн авсан хүү,ноогдол ашиг | | |
| 2.2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | | |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Гаргасан хувьцаа | 288500009.8 | |
| 3.2 | Банкнаас авсан зээл /+/ | | |
| 3.3 | Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр | | |
| 3.4 | Зээлийн төлөлт /-/ | | |
| 3.5 | Улсаас өгсөн санхүүжилт /+/ | | |
| 3.6 | Төрөл бүрийн хандив /+/ | 2780000 | |
| | Урт хугацаат өрийн тайлангийн үеийн төлөлт /-/ | | |
| | Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа /-/ | | |
| 3.9 | Мөнгөөр төлсөн ноогдол ашиг | | |
| 3.1 | Хүү ба урамшууллын орлого | | |
| 3.11 | Валютын ханшны зөрүү | | |
| 3.2 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | 291280009.8 | |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | 186774661.8 | |
| 5.1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 5.2 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 186774661.8 | |

Захирал ____________ /Ж. Бат /

Нягтлан бодогч ____________ /Ч. Баатархүү/

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДИСЕК"
ХК
ТТА4467 2052482

НАКО ТҮЛШ
ХК

65

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

**НАКО ТҮЛШ ХХК**

2007 он 12 сар 31 өдөр

(төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | Хувьцаат капитал | Хувьцааны урамшуулал | Дахин үнэлгээний нөөц | Хөрвүүлэх нөөц | Хуримтлагд сан ашиг/алдагдал/ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 2007 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 488500009.8 | | | | -14790197 | 473709812.8 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| Өмчийн дахин үнэлгээний өөрчлөлт | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний бууралт | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | | | | | |
| Ногдол ашиг | | | | | | |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 2007 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | | | |
| Өмчийн дахин үнэлгээний өөрчлөлт | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй цэвэр олз, гарз | | | | | | |
| Тайлант хугацааны цэвэр ашиг | | | | | | |
| Ногдол ашиг | | | | | | |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 2007 оны 12-р сарын 30-нээрх үлдэгдэл | 488500009.8 | | | | -14790197 | 473709812.8 |

Захирал ........................ /Ж. Бат/

Ня-бо ........................ /Ч.Баатархүү/

Сангийн сайдын 2005 оны 12 дугаар
сарын 30-ны өдрийн 385 тоот
тушаалын 3 дугаар хавсралт

Регистрийн дугаар: | 4 | 4 | 8 | 9 | 9 | 6 | 9 |

# НАКО ТҮЛШ ХК-НИЙ
# 2008 ОНЫ 04-Р УЛИРЛЫН
# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| Хянаж хүлээн авсан байгууллагын нэр | Сар, өдөр | Гарын үсэг |
|---|---|---|
| | | [illegible] |
| [illegible] | 2009.2.9 | [illegible] |
| НДХ | 9/4 2009 г | [illegible] |
| | | |

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДИСЕК"
ХК
ТТА4467 ж 2052482

НАКО ТҮЛШ
ХК
ТТГ3516 ж 4489969

## БАЛАНС

2008 оны12 сарын 31 өдөр

**Нако түлш ХК**

**(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)** (төгрөгөөр)

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1-р сарын 1 | 12-р сарын 31 |
| А | Б | 1 | 2 |
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 186,774,661.80 | 2295284.67 |
| 1.1.2 | Богино хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.1.3 | Үнэлгээний хасагдуулга | | |
| 1.1.4 | Дансны авлага | 44,591,151.00 | 18,092,502.00 |
| 1.1.5 | НӨАТ-н авлага | | 45,367,906.00 |
| 1.1.6 | Бусад авлага | | |
| 1.1.7 | Бараа материал | 12,636,000.00 | 4,949,639.00 |
| 1.1.8 | Мал, амьтад | | |
| 1.1.9 | Урьдчилж төлсөн зардал /тооцоо/ | | 170,766,780.00 |
| 1.1.10 | | | |
| 1.1.20 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 244,001,812.80 | 241,472,111.67 |
| 1.2 | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | | 552,670,083.80 |
| 1.2.2 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.3 | Бусад үндсэн хөрөнгө | | |
| 1.2.4 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.5 | Дуусаагүй барилга | 28,000,000.00 | 149,387,550.00 |
| 1.2.6 | Мал, амьтад (ХАА-н үйлдвэрлэлийн) | | |
| 1.2.7 | Биет бус хөрөнгө | 204,488,000.00 | 204,488,000.00 |
| 1.2.8 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 1.2.9 | Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | |
| 1.2.10 | Үнэлгээний хасагдуулга | | |
| 1.2.11 | | | |
| 1.2.20 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | 232,488,000.00 | 906,545,633.80 |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 476,489,812.80 | 1,148,017,745.47 |
